



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 10 сарын 21 өдөр

Дугаар А/367

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Авто замын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2, 12.1.4, 12.1.8, 28 дугаар зүйлийн 28.1, Зам тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 49 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мөрөн сумын “Шинэ Мөрөн” хорооллын авто зогсоол, замын тэмдэг тэмдэглэгээ, засвар арчлалт болон хурдан морины зам дагуух авто замын засвар арчлалтын ажлыг хүлээж авах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:

Б.Энхжаргал (Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын  
Барилга хот байгуулалтын хэлтсийн дарга)

Гишүүд:

Х.Даваасүрэн (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого  
төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн,  
Ерөнхий архитектор)

Г.Ням-Эрдэнэ (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Архивын тасгийн  
сан хөмрөгийн эрхлэгч)

Д.Нямбат (Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын  
мэргэжилтэн)

Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл:

Ц.Мөнхбаатар (“ХӨВСГӨЛ АЗЗА” ТӨХК-ийн инженер)

Ашиглагч байгууллагын төлөөлөл:

Ш.Баасанпүрэв (Мөрөн сумын Архитектор, дэд бүтэц, нийтийн тээвэр  
хариуцсан мэргэжилтэн)

С.Мөнх-Эрдэнэ (Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв ХХК-ийн Захирал)

Комиссын нарийн бичгийн дарга:

Б.Баасанжав (Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын  
мэргэжилтэн)


2. Мөрөн сумын "Шинэ Мөрөн" хорооллын авто зогсоол, замын тэмдэг тэмдэглэгээ, засвар арчлалт болон хурдан морины зам дагуух авто замын засвар арчлалтын ажлыг хүлээж авах үйл ажиллагааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулж, ажлын хэсгийн тайлан, шийдвэрийг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг ажлын хэсгийн дарга (Б.Энхжаргал)-д даалгасугай.

3. Мөрөн сумын "Шинэ Мөрөн" хорооллын авто зогсоол, замын тэмдэг тэмдэглэгээ, засвар арчлалт болон хурдан морины зам дагуух авто замын засвар арчлалтын ажлыг хүлээж авсантай холбоотой баримт бичгийг бүрдүүлэн аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасаг болон холбогдох байгууллагуудад хүлээлгэн өгөхийг Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга (Б.Баасанжав) -д үүрэг болгосугай.

4. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн чанаргүй ажил хүлээн авсан тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгүүлэхийг анхааруулсугай.

5. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН